

ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН 2024 ОНЫ ХАГАС ЖИЛД АЛБА ХААГЧ
БОЛОН ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ,
ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН ТУХАЙ

2024 оны 06 дугаар
сарын 20-ны өдөр

Улаанбаатар
хот

Онцгой байдлын байгууллага нь “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай хууль”, Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоолыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж Онцгой байдлын байгууллагын хэмжээнд 2024 оны хагас жилийн байдлаар 2519 өргөдөл, гомдол, санал хүлээн авч, тэдгээрийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэж тайлан, мэдээг тухай бүр гарган ажиллаж байна.

Онцгой байдлын ерөнхий газарт 2024 оны хагас жилд 109 өргөдөл ирснээс 91 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, бусад байгууллагад 5 иргэний өргөдлийг шилжүүлж шийдвэрлүүлсэн, 18 өргөдөл хяналтын шатандаа явж байна. Нийт өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 83.6%-ийн хэрэгжилттэй байна.

Онцгой байдлын байгууллагын 2024 оны хагас жилд хүлээн авч, шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тайланг гарган 2, 3, 4 дүгээр хавсралтаар тус тус хүргүүлж байна.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН 2024 ОНЫ ХАГАС ЖИЛД АЛБА ХААГЧ
БОЛОН ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ
ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэлт				
			Шийдвэрлэж хариу өгсөн	Шилжүүлж шийдвэрлүүлсэн	Хугацаа хэтрүүлж /сунгаж/ шийдвэрлэсэн	Хугацаа болоогүй /хяналтад /	Шийдвэрлэлтийн хувь
1	Онцгой байдлын ерөнхий газар	109	91	-	-	18	83.6%
2	Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллага	2410	2311	-	-	99	95.8%
Нийт		2519	2402	-	-	117	89.7%

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН 2024 ОНЫ ХАГАС ЖИЛД АЛБА ХААГЧ
БОЛОН ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ ХҮСЭЛТ

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэлт				
			Бичгээр	Цахим	Утас	Биечлэн	Бусад
1	Онцгой байдлын ерөнхий газар	109	108	-	1	-	-
2	Төв орон нутгийн Онцгой байдлын байгууллага	2410	2398	-	12	-	-
Нийт		2519	2506	-	13	-	-
Тайлбар: Монгол Улсын Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах “11-11” төвөөс шилжиж ирсэн санал хүсэлтийг тайланд оруулаагүй болно. 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар.							

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТИЙН АГУУЛГА

№	Байгууллагын нэр	Зонхилж байгаа асуудал /тоо, нийт өргөдөл гомдолд эзлэх хувь/
1	Онцгой байдлын ерөнхий газар	Нийт 2519 өргөдлөөс Хүсэлт – 2500 / 99.2% Санал – 12 / 0.6% Гомдол – 7 / 0.2% - Ажилд орох, чөлөөлөгдөх, тэтгэвэр тэтгэмж, тусламж чөлөө, цалин хөлс зэрэг алба хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгаатай холбоотой асуудлаар – 2392 / 93.1% - Сургалт, сургуульд хамрагдах, мэдээлэл лавлагаа авах, нийгмийн асуудлаа шийдвэрлүүлэх асуудлаар – 95 / 4.7% - Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар – 32 / 2.2% - 2024 оны хагас жилд Онцгой байдлын байгууллагад ажилд орох, алба хаагчид цэргийн тэтгэвэрт гарах, гачигдлын чөлөө, цалин хөлстэй холбоотой асуудлаар ирсэн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэж ажиллаа. - Онцгой байдлын байгууллагад анх орох иргэн болон алба хаагчид төрөл, мэргэжлийн сургалтад хамрагдах, нийгмийн асуудлаа шийдвэрлүүлэхээр гаргасан өргөдлийг хүлээн авч холбогдох шатны сургуульд хамруулж, албан тушаалд томилогдох асуудлыг шийдвэрлэж байна. - Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар гаргасан хүсэлтийг тухай бүр нь судлан шийдвэрлэж, хариу өгч ажиллалаа.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР